



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2017. оны 07 сарын 06 өдөр

Дугаар А/132

Мандалговь

Г

Гэрээ байгуулах тухай

Г

Монгол улсын Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоол, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдэх “Сүм хөх бүрд” аялал жуучлалын газрын тохижилтын ажил “ДУОНӨГ/2017/00021/10”-ийн гүйцэтгэгчээр “Орон нутгийн өмчит нийтлэг үйлчилгээ, үйлдвэрийн газар”-ыг сонгон 7,446,000 /долоон сая дөрвөн зуун дөчин зургаан мянга/ төгрөгөөр шууд гэрээ байгуулсугай.

Хоёр. Тохижилтын ажлыг төслийн дагуу гүйцэтгэж, хүлээлгэн өгөхийг “Орон нутгийн өмчит нийтлэг үйлчилгээ, үйлдвэрийн газар”-ын дарга /Б.Наранцэцэг/-д үүрэг болгосугай.

Гурав. Дээрх байгууллагатай гэрээ байгуулж, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс /Н.Эрдэнэ-Очир/-т үүрэг болгосугай.

ДАРГА



О.ЧУЛУУНБАТ

0200292